



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 07 сарын 01 өдөр

Дугаар 5/518


Улаанбаатар хот

С.Сумидыг ажлаас чөлөөлж, нэг удаагийн
буцалтгүй тусlamж олгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэг, 82 дугаар зүйлийн 82.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 271¹ дүгээр зүйлийн 271¹.1.7, 271¹.1.10 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусlamж олгох журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өндөр насын тэтгэвэр тогтоолгох хүсэлтээ гаргасан Гаалийн ерөнхий газрын харьяа Замын-Үүд дэх гаалийн газарт мал эмнэлгийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагчаар түр томилогдон ажиллаж байгаа Сайжрахын Сумидыг 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.
2. С.Сумидад төрийн албан хаагч өндөр насын тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусlamж болох 17 686 850 /арван долоон сая зургаан зуун наян зургаан мянга найман зуун тавин/ төгрөгийг холбогдох журмын дагуу олгохыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Д.Долгорсүрэн/-т зөвшөөрсүгэй.
3. Ажлаас чөлөөлөгдж байгаа С.Сумидын гаалийн улсын байцаагчийн хувийн дугаар бүхий тэмдэг, ялгах тэмдгийг хүлээн авч, холбогдох тооцоог зохих журмын дагуу хийхийг Замын-Үүд дэх гаалийн газар /Б.Отгонсүх/-т даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Бат-Эрдэнэ/-т даалгасугай.

ДАРГА



Б. АСРАЛТ